



Одоогийн байдлаар одоо ашиглагдаж байгаа хэсэгчилсэн халаалтын зуухны барилгын насосны өрөө дулаан хангамжийн 2 дугаар хэлхээний тоног төхөөрөмжийг суурилуулах зай талбай хүрэлцэхгүйгээс шалтгаалан ялтсан больер суурилуулах ажил хийгдээгүй байна.

Дулааны станцын цахилгаан хангамжийн зураг, төсвийг мэргэжлийн байгууллагаар 2011 онд хийлгэсэн. 478 779 722 төгрөгийн төсөвт өртөгтэй. 110/35/10 кВ-ын Булган дэд станцаас 10 кВ-ын 2 ширхэг гаргалгаатайгаар 2 хэлхээ газрын кабелиар аваарийн нөөц цахилгаан хангамжийн эх үүсвэртэйгээр хийгдсэн.

Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд 170,0 сая төгрөг төлөвлөгдөж, Эрчим хүчний газраас эхний ээлжинд дулааны станцын цахилгаан хангамжийг 1 хэлхээ 10 кВ-ын агаарын шугамаар тэжээхээр зураг төсөв хийгдэж, гүйцэтгэгчээр Номин Ендерт ХХК шалгарч, барилга угсралтын ажил хийгдсэн.

Гэвч дулааны станцын цахилгаан хангамжид техникийн нөхцөлөөр аваарийн нөөцийн цахилгааны эх үүсвэр зайлшгүй байх шаардлагатай тул үлдсэн 1 хэлхээ цахилгаан хангамжийн эх үүсвэрийг байгуулахад шаардагдах 308,0 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр шаардлагатай.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2011 онд /Дулааны шугамын өргөтгөл/ - 585,0 сая, 2012 онд /Дулааны станцын цахилгаан хангамж, цахилгаан дамжуулах агаарын шугам/-170,0 сая төгрөг, Эрдэс баялаг эрчим хүчний сайдын багцаас 322,5 сая төгрөг, нийт 1077,5 сая төгрөг зарцуулсан.

2012 î í û 8 äóããàð ñàðààñ хөрөнгө оруулагч “Сэлэнгэ дулаан” ХХК-ийн санхүү, мөнгөний хүндрэлээс шалтгаалан барилга угсралтын ажил зогссон.

Хөрөнгө оруулагч “Сэлэнгэ констракшн” ХХКомпани 2011 онд “Сэлэнгэ дулаан” ХХК, 2012 онд “Термоинженерг консалтинг” ХХК, 2013 оны 10 дугаар сард “Булганы дулааны станц” ХХК, 2014 онд “Энержи плас” ХХК болон нэрээ 4 удаа ч өөрчилсөн.

Áóëããí ñòí ùí äóëääí ù ñààí öüí áàðëëää óãñðàëëòüí àæилд дутагдаж байгаа 3,0 тэрбум төгрөг, концессын гэрээ байгуулах асуудлыг Монгол улсын Засгийн газар болон холбогдох яамдад уламжлан шийдвэрлүүлж, барилга угсралтын ажлыг үргэлжлүүлж байна. Барилга угсралтын ажил 80,0 хувьтай байна.

Барилга угсралтын ажилд Эрчим хүчний хөгжлийн төвөөс хяналт тавин ажиллаж байна. Санхүү, хөрөнгийн дутагдал, цаг агаар хүйтэрч, өвлийн улирал эхэлж байгаатай холбогдуулан барилга угсралтын ажлыг түр зогсоов. 2016 оны 2 дугаар улиралд багтаан гүйцэтгэхээр төлөвлөж байна.

